

**2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 06 дугаар 19		Улаанбаатар хот		
Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
Үүрэг даалгавар НЭГ. Үндэсний их баяр наадам болон "Хотын иргэдийн баяр - Хүрээ даншиг" наадмын нэгдсэн арга хэмжээний бэлтгэл, иргэд, олон нийтийн аюулгүй байдал, орчны ногоон байгууламж, тохижилтын ажил зэргийг сайтар хангах.				
1	Үндэсний их баяр наадам болон "Хотын иргэдийн баяр - Хүрээ даншиг" наадмын нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газартай гэрээтэй ажилладаг хог тээвэр болон зам талбайн цэвэрлэгээний чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад тухай бүр үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.			30
Үүрэг даалгавар ХОЁР. Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэж байгаа ажлуудын газар чөлөөлөлтийг бүх шатанд эрчимжүүлж, дараагийн шуурхайн зөвлөгөөн дээр явцыг танилцуулах.				
2	<p>1. Дүүргийн 17 дугаар хороо, 960 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилгын нөлөөлөлд өртсөн 45 нэгж талбараас 5 нэгж талбар үлдсэнээс 3 нэгж талбарыг тус байршлын нөлөөллөөс гаргахаар болсон бөгөөд үлдсэн 2 нэгж талбарт 2025 оны шинэчилсэн хөрөнгийн үнэлгээ хийн зөвшилцөж 2025 оны 06 дугаар сарын 16-нд гэрээ байгуулсан.</p> <p>2. Дүүргийн 13 дугаар хороо, тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын нөлөөлөлд өртсөн нэгж талбаруудаас 4 нэгж талбар үлдсэнээс газар эзэмших эрхгүй 1 нэгж талбарын хүсэлтийг дүүргийн Газар зохион байгуулалтын албанд өгсөн ч шийдвэрлэгдээгүй байна. Үлдсэн 3 нэгж талбар хөрөнгийн үнэлгээний үнийн дүнгээс татгалзсан байсныг 2025 онд шинэчлэн хөрөнгийн үнэлгээ хийлгэж 2 нэгж талбартай зөвшилцөж гэрээ байгуулахаар болсон. Үлдсэн 1 нэгж талбарын нийтийн орон сууцны эд хөрөнгийн үнэлгээний тайлан ирээгүй байна.</p> <p>3. Дүүргийн 9 дүгээр хороо, дүүргийн Төр захиргааны байр барих газрын нөлөөлөлд өртсөн нийт 112 нэгж талбараас чөлөөлсөн 105 нэгж талбар, үлдсэн 7 нэгж талбарт 2025 оны 04 дүгээр сарын 30-нд 6 нэгж талбарт эд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн үнэлгээний</p>			50

	<p>тайлан ирээгүй байна. Үлдсэн 1 нэгж талбарын эзэн нь гадаадад байдаг тул холбогдож чадаагүй газар чөлөөлөх ажил үргэлжилж байна.</p> <p>4. Дүүргийн 10 дугаар хороо, дүүргийн Нэгдсэн эмнэлгийн бие даасан дулааны эх үүсвэр барих байршлын газар чөлөөлөлтөд өртсөн нийт 26 нэгж талбараас 18 нэгж талбарт эд хөрөнгийн үнэлгээ хийлгэн үлдсэн 8 нэгж талбарт үнэлгээ хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>5. Дүүргийн 10 дугаар хороо, Өрхийн эрүүл мэндийн төв барих барилгын газар чөлөөлөлтөд өртсөн нийт 6 нэгж талбараас 4 нэгж талбарт үнэлгээ хийлгэсэн үнэлгээний тайлан гараагүй байна. Үлдсэн 2 нэгж талбарт үнэлгээ хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>6. Дүүргийн 18 дугаар хороо, Сэлбэ дэд төвийн нөлөөлөлд өртсөн нийт 6 нэгж талбарт эд хөрөнгийн үнэлгээ хийлгэхээр зөвшилцөж захирамжийн төсөлд хянуулахаар өгсөн.</p> <p>7. Дүүргийн 17 дугаар хороо, ЗХЗ сагсан бөмбөгийн талбай барих нөлөөлөлд өртсөн байршилд эд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн 1 нэгж талбар дээр тайлан ирсэн, 2 нэгж талбар дээр үнэлгээний тайлан ирээгүй байна.</p> <p>8. Дүүргийн 7 дугаар хороо, 173 дугаар цэцэрлэгийн зогсоол барих газар нөлөөлөлд өртсөн. Тус байршилд эд хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн тайлан гараагүй байна.</p>	
	<p>Үүрэг даалгавар ГУРАВ. Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлуудаа олон, нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.</p>	
3	<p>Дүүргийн Засаг даргын 2025 оны А/222 дугаар захирамжийн хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг засварлах, зөрчлийг арилгах, хотын стандартыг мөрдүүлэх 78 ажлын байршилд газар дээр нь ажиллаж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэсэн.</p>	70
	<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ. Хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>	
4	<p>Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын дагуу 1,404,346,685.88 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэсэн.</p>	90
	<p>Үүрэг даалгавар ТАВ. Дүүргүүд нийслэлийн өмчийн ашиглалтгүй талбайг түрээслэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг нийслэлийн Өмчийн харилцааны газартай зөвшилцөж, гэрээ байгуулаагүй зөрчлүүдийг арилгах.</p>	


5	<p>Дүүргийн 7, 8, 10-18 дугаар хороодод байрлалтай 3850 ширхэг гэрэлтүүлгийн шонг “Юни трансмишн нэтворк” ХХК-д ашиглуулах гуравласан гэрээг нийслэлийн Өмчийн харилцааны газар, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хийсэн. Мөн дүүргийн “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК-д дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны подвалын давхарт байрлах 127 м2 өрөөг түрээслэх гуравласан гэрээг нийслэлийн Өмчийн харилцааны газар, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хийсэн.</p>			90
<p>Үүрэг даалгавар ЗУРГАА. Нийслэлийн хэмжээнд ой хээрийн түймрийн улмаас учирсан хохирлын үнэлгээг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.</p>				
6	<p>2025 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 10 цаг 49 минутад Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо, Залаатын аманд гарсан ой, хээрийн түймрийн хэргийг дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, дэслэгч М.Мөрөнболд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Чингэлтэй хайрхан, Зүрх-Уул, Залаатын ам, Шадивлан, Яргайт, Жигжид /моби/, Жигжид /аранзат/, Жигжид /гүнт/, Майхан толгой, Санзай, Халзангийн даваа зэрэг амуудад Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги, 6 алба хаагч, 2 тээврийн хэрэгсэлтэй 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд өдөр бүр 10:00 цагаас 20:00 цагийн хооронд нийт 60 хоногийн хугацаатайгаар өдөр бүр давхардсан тоогоор 360 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэн хоол хүнсэнд 3.960.000 төгрөг, ой, хээрийн гал түймэр унтраах зориулалт бүхий 2 тээврийн хэрэгсэл 1800 километр хөдөлгөөн үйлдэж 417 литр шатахуун, 1.880.280 төгрөгийн зарцуулалт хийж хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ногоон бүсэд нэвтэрч алхалт хийж буй нийт 4158 иргэнд “Ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” талаар заавар зөвлөмж өгч, 2000 ширхэг урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийн материал өгч ажилласан.</p>		<p>2025 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 10 цаг 49 минутад Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо, Залаатын аманд гарсан ой, хээрийн түймрийн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд Гамшиг судлалын Үндэсний төвийн шинжээчийн дүгнэлт гарснаар дүүргийн засаг даргын “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох”</p>	90

		захирамж гаргуулан ажлын хэсгийг томилж шийдвэрлэх	
<p>Үүрэг даалгавар ДОЛОО. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг амарч байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажлыг хугацаанд нь эхлүүлж, дуусгах.</p>	<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг амарч байгаатай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажлыг хугацаанд нь эхлүүлж, дуусгах үүрэг даалгаврын дагуу байгууллагын урсгал засвараар хийгдэх засвар, тохижилтын ажлууд хийгдэж байна. Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх их засварын ажлуудын гүйцэтгэгч шалгаруулах ажлууд хуулийн хугацааны дагуу хийгдэж байна. Дүүргийн хэмжээнд сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2 барилга, хүүхдийн цэцэрлэгийн 4 барилга, сургуулийн 2 барилга, дахин төлөвлөлтөөр цэцэрлэгийн 1 барилгын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 3 төсөл, арга хэмжээ газар чөлөөлөлтийн шатанд, 6 төсөл, арга хэмжээ 30-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний хамт Чингэлтэй дүүрэгт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг 2025 оны 06 дугаар сард багтаан газар дээр нь үзэж, танилцан хяналт тавьж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	<p>Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг тавьж, ажлыг эрчимжүүлэх, их засвар хийж гүйцэтгэх компанийн шалгаруулалтыг яаралтай хийж, ажлыг эхлүүлэх</p>	<p>30</p>
<p>Үүрэг даалгавар НАЙМ. Нийслэлийн хэмжээнд 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, танилцуулах.</p>			
<p>8</p>	<p>Дүүргийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулахаар бэлтгэл ажлыг хангасан.</p>		<p>30</p>
<p>Үүрэг даалгавар ЕС. Дүүргийн нутаг дэвсгэр дэх үерийн хамгаалалтын далан суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх.</p>			
<p>9</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үерийн хамгаалалтын далан суваг, гуу жалга, борооны ус зайлуулах шугам сүлжээнд хуримтлагдсан үүсмэл хог хаягдлыг дүүргийн "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК, "Найши трейд" ХХК-ний харьяа иргэдийн бүлгийн 32 ажилтан хуваарийн дагуу 7 хоногт 2 удаагийн давтамжтай түүвэр цэвэрлэгээг хариуцан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 822,569 м2 талбайн 756.5 тонн үүсмэл хог хаягдал болон цэвэрлэгээнээс гарсан лаг шаврыг цуглуулж тээвэрлэн ажиллаж байна.</p>		<p>70</p>
<p>Үүрэг даалгавар АРАВ. Дүүрэгт авто зам, инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гаднах орчны аюулгүй байдлыг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>			

10	<p>Дүүргийн 4, 5, 6 дугаар хороо, Л.Лааганы гудамжны авто замын засвар шинэчлэлтийн ажлыг нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Киото хайвэй" ХХК хэрэгжүүлэн ажиллаж буй бөгөөд уг авто замын дагуух нийтийн эзэмшлийн гудамж талбайн явган хүний зам дээр байрлуулсан 4 гэрэлтүүлгийг дүүргийн төсвийн хөрөнгөөр шилжүүлж орчны аюулгүй байдлыг хангасан. Мөн үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээг хийлгэх тухай 03/1815 тоот албан бичгийг нийслэлийн Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.</p>			50
<p>Үүрэг даалгавар АРВАННЭГ. Замын засвар шинэчлэл, тохижилтын ажлууд эхэлсэнтэй холбогдуулан замын бродюр, явган зам, алаг хавтангуудыг Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр дээр буулгах.</p>				
11	<p>Ашиглалтын шаардлага хангахгүй, дахин ашиглах боломжгүй болсон авто зам, явган замын хашлага, явган замын хавтан зэрэг барилгын хог хаягдлыг дүүргийн "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ болон хог хаягдлын тээвэрлэгч байгууллага "Найши трейд" ХХК, "Чингэлтэй тохижилт үйлчилгээ" ХХК-иудад Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгт ашиглалтад орж байгаа барилгын хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт буулгах талаар чиглэл хүргүүлсэн.</p>			30
<p>Үүрэг даалгавар АРВАНХОЁР. Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх, тохижуулах ажлуудыг эрчимжүүлэх.</p>				
12	<p>Дүүргийн Засаг даргын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тухай 2025 оны А/220 дугаар захирамжийн хүрээнд Баянбүрдийн тойргоос 17 дугаар сургуулийн уулзвар хүртэл замын баруун талын нийтийн эзэмшлийн талбайд зүлэгжүүлэлт, нарс мод, ургамлан хашлага буюу хайлаас тарьж ургуулах ажил 50 хувьтай үргэлжилж байна. Мөн Энхтайваны өргөн чөлөө, Цэцэг төвийн уулзвараас Баруун 4 замын уулзвар хүртэл замын хойд талд байсан авто замын карма зогсоол байсан хэсэгт ногоон байгууламж бий болгох ажлыг эхлүүлээд байна.</p>			30
<p>Үүрэг даалгавар АРВАНГУРАВ. Нийслэлийн хэмжээнд тоос, тоосонцроос урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, автозам, явган хүний зам талбайг усалж, чийгшүүлэх ажлыг сайтар зохион байгуулах.</p>				
13	<p>Дүүргийн "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ-аас дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн усалгаанаас тусдаа усны машин гаргаж гудамж, зам талбайд усалгаа, чийгшүүлэлтийн ажлыг өдөр бүр тогтмол хийж байна.</p>			90
<p>Үүрэг даалгавар АРВАНДӨРӨВ. Нийслэлийн хэмжээнд ТҮЦ-ийг цэгцлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.</p>				

14	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Хууль тогтоомжийн хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/237 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2025 оны "Газар албадан чөлөөлөх тухай" А/117 дугаар захирамжаар түргэн үйлчилгээний цэгийг албадан буулгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж батлагдсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, Эрүүл мэндийн төв, Онцгой байдлын хэлтэс, "УБЦТС" ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв, хороодын Засаг даргын ажлын алба хамтран 2025 оны 04 дүгээр сарын 10, 12, 16, 18, 05 дугаар сарын 21, 06 дугаар сарын 03, 14-ний өдрүүдэд 20:00-05:00 цаг хүртэл дүүргийн 1-23 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулсан нийт 105 түргэн үйлчилгээний цэгийг албадан нүүлгэж, газар чөлөөлж, үүрэг гүйцэтгэн ажилласан.</p>		90
15	<p>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Улаанбурханы тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан хариу арга хэмжээг авч, хяналт тавин ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Монгол Улсын Шадар сайдын 28 дугаар тушаалын дагуу 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 16 ӨЭМТ өөрийн хорооны эрсдэлийн үнэлгээг хийсэн. Үүнээс 11 хороо улбар шар (өндөр эрсдэлтэй), 5 хороо шар (дунд эрсдэлтэй) эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна. Эрсдэлийн үнэлгээний дагуу хороодын ӨЭМТ-үүд Эрүүл мэндийн сайдын А/223 дугаар тушаал, ЧНЭ-ийн захирлын 85 дугаар тушаалуудын дагуу хариу арга хэмжээ, нөхөн дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөг тус бүр өөрийн хорооны онцлогт тохируулан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ✓ Чингэлтэй Нэгдсэн эмнэлгээс ТУТ багийг шинэчлэн тодотгол хийж, тасаг нэгжийн эрхлэгч, албаны дарга гэсэн нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулан, Улаанбурхан өвчний үеийн хариу арга хэмжээ, дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийхээр хуваарийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс ажиллаж байна. Дэмжлэгт хяналтын удирдамж гарган, 2025 оны 06 дугаар сарын 19-25-ны өдрүүдийн хооронд хороодын ӨЭМТ-үүдээр ажиллана. ✓ Улаанбурхан өвчний тохиолдлын хувьд 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 370 тохиолдол бүртгэгдэж, голомтын арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллаж байна. ✓ Дархлаажуулалтын хувьд 16 ӨЭМТ дээр байнгын болон явууллын цэг, уртасгасан цагаар Нэгдүгээр амбулатори, Гуравдугаар амбулатори дээр 17:30-22:00 цагт ажиллах түр 		90

	<p>цэгийг нээн ажиллуулж байна. Одоогийн байдлаар нөхөн дархлаажуулалт 40%, голомтын дархлаажуулалт 43%, эмнэлгийн ажилчдын дархлаажуулалт 89%-тай байна.</p> <p>✓ Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн нөөцөд бэлэн байгаа 2612 таблетка 200000 ОУН А амин дэмийг хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2025 оны 06 дугаар сарын 19, 20-нд хуваарилахаар хуваарь гаргасан. Хүүхдийн кабинетэд 200 таблетка 200000 ОУН А амин дэмийг хуваарилан, амбулаториор ирж тусламж авч буй 0-5 насны хүүхдүүдэд олгож байна.</p>			
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ				64.7%



ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.БУЯН-ӨЛЗИЙ

НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН